



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид  
худалдан авалт зохион байгуулах эрх олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4, 14.4 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хооронд 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан Эрүүл Мэндийн Салбарын Хөгжлийн Хөтөлбөр -4 төслийн гэрээ (0236-MON), 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан Эрүүл Мэндийн Салбарын Хөгжил Хөтөлбөр -5 төслийн гэрээ (2963-MON), Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10 ны өдрийн 196 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын 14.1.2, АХБ-ны Зөвлөх ашиглах журмын 1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд ажиллах нэгжийн ажилтан, зөвлөхийг сонгон шалгаруулах, Бараа, ажлын (100,000.00 ам доллар хүртэлх) худалдан авалтыг Азийн хөгжлийн банкны худалдан авах, зөвлөх ашиглах журамд тус тус нийцүүлэн зохион байгуулах эрхийг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж /А.Мөнхтайван/-д олгосугай.

2. Энэхүү тушаалын дагуу хийсэн бараа, ажил үйлчилгээний талаар тухай бүр тайлагнаж байхыг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж /А.Мөнхтайван/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Т.Баярсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080163